



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/311

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
захиалагчийн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2017 оны "Захиалагчийн дүрэм батлах тухай" 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны "Харьцуулалтын аргаар ажил худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" 124 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх, засвар шинэчлэлт хийх /Мөрөн сум / ажил нийлүүлэх ХӨАОНӨГ/202312026/ дугаартай тендерт 68,200,000 (Жаран найман сая хоёр зуун мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Дэвших Стандарт" ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Дэвших Стандарт" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГазар (Д.Батчулуун)-ыг томилсугай.


3. Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх, засвар шинэчлэлт хийх /Мөрөн сум / ажил нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатны хяналт хийх, ил далд ажлын актыг баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, барилгын ажлын үе шатанд хяналт хийж, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тайлагнах, уг тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГазар (Д.Батчулуун)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

d/A4

6712010825

4. Ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тус тус олгохыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР

